



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 8/325

Номгон

Г “БИ АЙ ЭМ БИ” ХХК-ийн эзэмшил газрын
зориулалтыг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2025 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 7.4, 7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Би Ай Эм Би” ХХК-ний хүсэлтийг харгалзан Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Лувсанданзанжанцангийн Өргөн чөлөө-5, 517 тоот хаягт байрлах Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалттай 1305 м2 эзэмшлийн газрын зориулалтыг Үйлчилгээтэй орон сууц болгон өөрчилсүгэй.

2.Зориулалт өөрчлөгдсөн газрын мэдээллийг хавсралтаар баталсугай.

3.Зориулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан өөрчлөлтийг цахим системд бүртгэн цахим гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4.Эзэмшил газрыг гэрээнд заасан үүргийн дагуу зүй зохистой ашиглахыг газар эзэмшигч “Би Ай Эм Би” ХХК захирал (Г.Долгорсүрэн)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны 5 дугаар сарын
29-ний өдрийн 1345 дугаар захирамжийн
хавсралт



ГАЗАР ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Газар эзэмшигчийн мэдээлэл									
№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Газар ашиглалтын зориулалт	Газар эзэмших, ашиглах эрхийн төрөл	Нэгж талбарын хаяг, байршил	Газрын хэмжээ (м.кв- аар)	Өөрчлөгдөж буй газар ашиглалтын зориулалт	Газар эзэмшүүлэх, ашиглуулах хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9	10
1	"Би Ай Эм Би" ХХК	5863821	6409014205	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор	Эзэмших	Баянхонгор сум, Рашаант 10- р баг, Лувсанданзанжанцангийн Өргөн чөлөө-5, 517 тоот	1305	Үйлчилгээтэй орон сууц	6 жил

---oOo---

